



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/329

Өлгий

Хөрөнгө зарцуулах тухай



Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.2, 17.2.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах зорилгоор Өлгий сумын ногоон байгууламжуудад мод тарихад зориулж өнжмөл бууц /хар шороо/-г Бугат сумын нутаг дэвсгэрээс ачиж буулгах зардалд 15,000,000 /арван таван сая/, мод, сөөгийн үрийн нөөц бүрдүүлэх ажилд 5,000,000 /таван сая/, нийт 20,000,000 /хорин сая/ төгрөгийг Байгаль хамгаалах сангаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Т.Фестиваль/-т зөвшөөрсүгэй.

2. Дээрх санхүүжилтийг зориулалтын дагуу зүй зохистой зарцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Ш.Марат/-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс /Х.Анар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАУЫРЖАН

0101220994

ТӨЛБӨРИЙН ХҮСЭЛТ № 72

2022 оны 5 сарын 24 өдөр

| | | |
|---|---|----------------------|
| Байгууллагын нэр: Байгаль орчны газар | Дансны дугаар | 15,000,000.00 |
| Регистрийн дугаар: 9006974 | 100020013001 | |
| Хүрээ авагчийн нэр: УЛУДАГ ХХК | Дансны дугаар | |
| Регистрийн дугаар: 3072517 | 291401874959 | |
| Хүлээн авагчийн банк: Төрийн банк | Ангилал | |
| Мөнгөн дүн үсгээр: Арван таван сая төгрөг 00 мөнгө | | |
| Үйлгээний утга: | 71406 - Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол | |
| Хар шорлоо, бууц | 81701 - Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | |
| | 0000 - Төрийн сан | 15,000,000.00 |
| | 210801-Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | |

Төлбөрийн хувдас № 72

| Үндэслэх бичиг баримтын нэр | Он сар, дугаар | Төрийн сангийн тэмдэглэгээ |
|-----------------------------|-------------------------|----------------------------|
| Аймгийн ЭДЗахирамж | 2022.05.10 №А/329 | ✓ |
| Гэрээ | 2022.05.11 №БОХ-04/2022 | ✓ |

Тамга

Дарга: *[Signature]* /Ш.Марат/
Нягтлан бодогч: *[Signature]* /Х. Тилеухан/

Төрийн санд гүйлгээ хийсэн
..... оны сарын өдөр
тэмдэг, гарын үсэг




**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/15

Өлгий

Хөрөнгө зарцуулах тухай



Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/329 тоот захирамж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын аймгийн Засаг даргатай 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2022 оны төсөвт тусгагдсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас Өлгий сумын ногоон байгууламжуудад мод тарихад зориулж өнжмөл бууц /хар шороо/-г Бугат сумын нутаг дэвсгэрээс ачиж буулгах зардалд 15000000 /арван таван сая/, ногоон төгөл цэцэрлэгт хүрээлэнгийн хашаанд мод услах худаг гаргах ажилд 4770000 /дөрвөн сая долоон зуун далан мянга/, нийт 19770000 /арван есөн сая долоон зуун далан мянга/ төгрөг зарцуулахыг нягтлан бодогч /Х.Тилеухан/-д зөвшөөрсүгэй.

2. Дээрхи арга хэмжээний ажлыг зохион байгуулах, гэрээ хийж гүйцэтгэлд хяналт тавьж дүгнүүлж ажиллахыг ойн асуудал хариуцсан мэргэжилтэн /Б.Хасым/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.МАРАТ

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
ДАРГА Ш.МАРАТ,



ГҮЙЦЭТГЭГЧ

Х.АЛДАБЕРГЕН/

БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № БОХ-04/2022

Нэг талаас [Байгаль орчин, аялал жуулчлалын газар] (цаашид "захиалагч" гэх)-ын дарга Ш.Марат, нөгөө талаас ["УЛУДАГ" ХХК] (цаашид "гүйцэтгэгч" гэх)-ын захирал Х.Алдаберген нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бүх нийтээр мод тарих ойжуулалт, ойг нөхөн сэргээх, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 онд Өлгий сумын аж ахуй нэгж байгууллагуудын ногоон төгөл цэцэрлэгт хүрээлэн, ойн зурвасын хашааны мод тарих ажилд хар шороо, өнжмөл бууц худалдан авч нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1 Гүйцэтгэгчээс гэрээт ажлын дагуу доорхи хүснэгтэд байгаа бараа материалыг хүлээж авах үүрэгтэй.

| д/д | Бараа материалын нэр, төрөл | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ /мян.төг/ | Нийт үнэ /мян.төг/ |
|-----|-----------------------------|----------------|-------------|-----------------------|--------------------|
| 1 | Хар шороо | м ³ | 200 | 60.0 | 12000.0 |
| 2 | Өнжмөл бууц | м ³ | 100 | 30.0 | 3000.0 |
| | Нийт | | | | 15000.0 |

2.2 Гүйцэтгэгчийн ажлын явцад үүссэн саад бэрхшээлийн улмаас гэрээт ажил хийгдээгүй буюу дутуу хийгдсэн тохиолдолд олгосон санхүүжилтийг буцаан нэхэмжлэх эрхтэй.

2.3 Ажил гүйцэтгэж байх хугацаанд Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон захиалагчаас хариуцсан мэргэжилтэн томилон гүйцэтгэлд хяналт тавина.

2.4 Захиалагч бүх нийтээр мод тарих ойжуулалт, ойг нөхөн сэргээх, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 онд Өлгий сумын аж ахуй нэгж байгууллагуудын ногоон төгөл цэцэрлэгт хүрээлэн, ойн зурвасын хашааны мод тарих ажилд хар шороо, өнжмөл бууц худалдан авч нийлүүлэхтэй **ажлын БОХ-04/2022**, -ийг (цаашид "гэрээний үүрэг" гэх) **[15.000.000 (арван таван мянган төгрөг)]** (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

2.4 Захиалагч нь барааны нийлүүлэлтийн _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, **15000000** төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. Захиалагч нь барааг хүлээж авсаны дараа гүйцэтгэгчид гэрээний үнийг 100 хувь шилжүүлж олгоно. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх явцад гарсан зөрчил, гологдлыг бүрэн арилгаагүй нь төлбөр хийхээс татгалзах үндэслэл болно.

2.5 Гэрээнд тусгасан ажлын хэрэгжилтийн явцад захиалагчаас томилогдсон ажлын хэсэг хяналт тавьж гүйцэтгэлийн хэмжээ, үр дүнг тодорхойлон дүгнэлт гаргана.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх үүрэг

3.1 Гүйцэтгэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болох стандарт чанарын шаардлага хангасан **бараа материал нийлүүлэх** ажлыг [бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, зөвлөх үйлчилгээ]-г 2021 оны 5 дугаар сарын 11-аас 2021 оны 5 дугаар сарын 16-ний өдрийн дотор гүйцэтгэнэ.

3.2 Гүйцэтгэгч ажлын чанарт сөргөөр нөлөөлөх эсхүл хугацаа хоцроож болзошгүй нөхцөл байдлын талаар захиалагчид аль болох урьдаас урьдчилан анхааруулах үүрэгтэй.

3.3 Гүйцэтгэгч нь захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

3.4 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дөрөв. Маргаан шийдвэрлэх

4.1 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан хобоогоор харилцана.

4.2 Гэрээний аль нэг тал үүргээ зөрчсөн тохиолдолд Иргэний хуулийн 225, 226 дугаар зүйлүүдэд заасан үндэслэл журмын дагуу нөгөө тал гэрээг цуцалж учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

БОАЖГазрын мэргэжилтэн Б.Хасым
Гарын _____
үсэг _____

ТАМГА

[Утас/факсын дугаар] 94509901

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"УЛУДАГ" ХХК-ний захирал
Гарын _____
үсэг _____



ТАМГА

[Утас/факсын дугаар] 99029025
[Харилцагч банкны нэр, дансны
дугаар]
Төрийн банк: 291401874959
РД: 3072517

АН СА
АЛТЭН

2022 онд Өлгий сумын аж ахуй нэгж байгууллагуудын ногоон төгөл цэцэрлэгт хүрээлэн, ойн зурвасын хашааны мод тарих ажилд хар шороо, өнжмөл бууц хүлээлгэн өгсөн жагсаалт

2022.05.09

| № | Байгууллагын нэр | Хэмжих нэгж | Хар шороо | Бууц | Хүлээж авсан хүний овог нэр албан тушаал | Гарын үсэг |
|------------|--------------------|----------------|------------|------------|---|---|
| 1 | БОАЖГазар | м ³ | 110 | 20 | БОАЖГазрын нярав Ө.Дауренбек |  |
| 2 | Өлгий сумын ХТАлба | м ³ | 90 | 80 | Өлгий сумын ХТАлбаны экологи, ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн А.Айбек |  |
| 3 | | | | | | |
| 4 | | | | | | |
| 5 | | | | | | |
| Дүн | | | 200 | 100 | | |

Хүлээлгэж өгсөн:
"УЛУДАГ" ХХК-ний захирал



Х. Алдаберген



